

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАШАА, ХАЙС БАРИХ, АШИГЛАХ, БУУЛГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь хотын өнгө үзэмж, тохижилт бүхий газар, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх, авто болон явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах, орчны бохирдлыг бууруулах зорилгоор хашаа, хайс барих, ашиглах, буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг нийслэлийн нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрээс үл хамааран дагаж мөрдөнө.

1.3. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах байршилд өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа газар, хуулиар тогтоосон хамгаалалтын болон тусгай бүс, хөдөө аж ахуйн бүсэд хашаа, хайс барих, ашиглах, буулгах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулахгүй.

1.4. Хашаа, хайс нь дараах төрөлтэй байна.

1.4.1. Хашаа нь эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, эд хөрөнгө хамгаалах зорилгоор хөдөлгөөн хязгаарлаж, эдэлбэр газрын хил заагаар орон зайг тусгаарласан байгууламж,

1.4.2. Хайс нь гудамж, зам, талбайн тохижилтыг хамгаалах, чимэглэх зориулалтын байгууламж,

1.4.3. Барилга, байгууламжийн хамгаалалтын түр хашаа нь тодорхой хугацаанд ашиглагдах зориулалтын байгууламж,

1.4.4. Амьд хайс нь нэг буюу түүнээс дээш эгнээ бүхий эмжээрлэн тарьсан бут сөөг;

Хоёр.Хашаа, хайс барих зориулалт

2.1. Хашааг дор дурдсан газар барьж болно.

2.1.1.Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтын байгууллагууд, тусгай объект,

2.1.2. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар,

2.1.3.Цэцэрлэг, ясли,

2.1.4.Бага, дунд, тусгай сургууль,

2.1.5. II, III шатлалын эмнэлэг, сувилал,

2.1.6. Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж,

2.1.7.Цэнгэлдэх болон цэцэрлэгт хүрээлэн, амьтны хүрээлэн,

2.1.8.Авто цогцолбор болон техникийн зах, худалдааны зах,

2.1.9.Бүх төрлийн эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлагыг хангуулах зориулалтын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас,

2.1.10.Цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис үйлдвэрлэх, ашиглах, агуулах зориулалтын барилга байгууламж,

2.1.11.Энгийн болон аюултай хог хаягдлын цэгийн барилга байгууламж,

2.1.12.Үйлдвэрлэл, агуулахын зориулалтын эдэлбэр газар,

2.1.13.Түүх, соёлын өв, дурсгалт газар, тэдгээрийн барилга байгууламж,

2.1.14. Амины орон сууц, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж, эзэмшиж байгаа эдэлбэр газар;

2.2. Хайсыг дараах зориулалтаар барина.

2.2.1.Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,

2.2.2.Явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах,

2.2.3.Худаг, рашаан, булаг, шандыг хамгаалах,

2.2.4.Хорооллын доторхи хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангах;

2.3. Түр хашааг дараах зориулалтаар барина.

2.3.1.Барилга болон инженерийн дэд бүтцийн барилга, байгууламж барих үед хөдөлмөр хамгааллын аюулгүйн ажиллагааг хангах,

2.3.1.1 Түр хашаа нь барилгын ажлын зөвшөөрлийн хугацаагаар байна.

2.3.2.Онцгой байдал зарласан, осол аваар гарсан газар, тодорхой объектыг тусгаарлах;

2.4. Амьд хайсыг орон сууц, олон нийтийн барилга, байгууламжийн эдэлбэр газрыг тусгаарлах зорилгоор байгуулна.

2.5. Хашаа, хайсыг журмын 3.3-т заасан даалгаврын дагуу барина.

2.6. Хашаа, хайс нь хот төлөвлөлтийн норм, архитектур төлөвлөлт орон зайн шаардлагад нийцсэн хэлбэр, хийцтэй байх ба явган зорчигчийн болон авто замын хөдөлгөөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих зам, хөдөлгөөний харагдах орчинг хязгаарлахгүй, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахааргүй байна.

Гурав. Хашаа, хайс барих, ашиглах, буулгах үйл ажиллагаа

3.1. Иргэн, хуулийн этгээд нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагад хашаа, хайс барих хүсэлтийг гаргана.

3.2. Нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.3. Хашаа, хайсны даалгаврыг Улаанбаатар хотын Ерөнхий архитектор батлана.

3.4. Батлагдсан даалгаврын хэрэгжилтэд нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавина.

3.5. Хашаа, хайс барих даалгаврыг газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, эдэлбэр газрын хил заагийг үндэслэн олгоно.

3.6. Тухайн даалгаврыг үндэслэн нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага хашаа, хайс барих, ашиглах гэрээ байгуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хувийн хэрэгт хавсаргана.

3.7. Нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага гэрээг жил бүр дүгнэнэ.

3.8. Гэрээ байгуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд албадан буулгах арга хэмжээг нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хашаа, хайсанд тавигдах шаардлага

4.1. Хашаа хайсны өндрийн хэмжээ дараах байдалтай байна.

Барилга, байгууламж		Хашаа, хайсны өндөр
4.1.1.	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтын байгууллагууд, тусгай объектын эдэлбэр газар	Нормын дагуу
4.1.2.	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар	Нормын дагуу
4.1.3.	Бага, дунд сургууль, тусгай сургууль	1.5 м дээш
4.1.4.	Цэцэрлэг, ясли	1.6 м
4.1.5.	II, III дугаар шатлалын эмнэлэг, сувилал	1.6 м
4.1.6.	Цэнгэлдэх, цэцэрлэгт болон амьтны хүрээлэн	1.6-2 м
4.1.7.	Авто цогцолбор болон техникийн зах, худалдааны төв	Нормын дагуу
4.1.8.	Бүх төрлийн эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлагыг хангуулах зориулалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүс	1.6-3.0 м
4.1.9.	Цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, багаж тоног төхөөрөмж ашиглах, үйлдвэрлэх, агуулах зориулалтаар	Нормын дагуу
4.1.10.	Аюултай хог хаягдалын цэг, барилга байгууламж	Нормын дагуу
4.1.11.	Үйлдвэрлэл, агуулахын зориулалтын эдэлбэр газар, цогцолбор барилга, байгууламж	1.6-2.0 м
4.1.12.	Түүх, соёлын өв, дурсгалт газар, барилга байгууламж	Нормын дагуу
4.1.13.	Амины орон сууц, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж, эзэмшиж байгаа эдэлбэр газар	0.8-2.0 м
Хайс		
4.1.14.	Авто зам тусгаарлах зориулалтаар	0.75-1.10 м
4.1.15.	Явган замыг тусгаарлах зориулалтаар	0.75 м хүртэл
4.1.16.	Ногоон байгууламжийг тусгаарлах зориулалтаар	0.75 м хүртэл
Түр хашаа – /3.0 м төмөр хашаа дээр нь 2.0 м тор байна./		5.0 м
Амьд хайс – /нэг эгнээ буюу түүнээс дээш/		1.0 м дээш

4.2. Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90, Барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт БНБД 12-01-09 норм, дүрэмд заасан шаардлагад нийцүүлнэ.

4.3. Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, явган зам, гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилтын хязгаарт орсон тохиолдолд хашаа, хайсыг буулгах болон шилжүүлэх асуудлыг газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдтэй зөвшилцсөний үндсэн дээр Захирагчийн ажлын алба, Нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага шийдвэрлэнэ.

Тав. Хашаа, хайс барихыг хориглох, буулгах

5.1. Журмын 1.4.3-т заасан түр хашаанд агаар, хөрсний бохирдол, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаагүй түр барилга, байгууламж байрлуулахыг хориглоно.

5.2. Энэ журмын 2.1, 2.2, 2.3, 2.4-т зааснаас бусад газарт хашаа, хайс барихыг хориглох ба барьсан тохиолдолд нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага ажлын 10 хоногийн хугацаанд буулгах шаардлага хүргүүлж, нийслэлийн мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэнэ.

5.3. Дор дурдсан тохиолдолд хашаа, хайсыг албадан буулгана.

5.3.1. Нийслэлийн барилгын асуудал эрхэлсэн байгууллагаас хүргүүлсэн хашаа, хайс, түр хашааг буулгах хугацаатай шаардлагыг биелүүлээгүй

5.3.2. Барилга байгууламжийн ажлын зөвшөөрөл олгосноос хойш жилийн хугацаанд барилга угсралтын ажил эхлээгүй түр хашаа

5.3.3. Газар эзэмших, ашиглах эрх нь хүчингүй болсон эдэлбэр газрын хашаа

5.3.4. Журмын 2.1, 2.2-т зааснаас бусад зориулалтаар хашаа, хайс барьсан

5.3.5. Эдэлбэр газрын хил заагаас хэтрүүлэн сунгасан хашаа, хайс, түр хашаа

5.3.6. Замын уулзварт үзэгдэх орчин хаасан хашаа, хайс, түр хашаа

5.4. Журмын 5.3-т заасан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй бол нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага хашааг албадан буулгаж, гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлж, нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

5.5. Энэ журмыг батлагдахаас өмнө барьсан хашаанд нөхөж зөвшөөрөл авна.

Зургаа. Хариуцлага

6.1. Журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____оОо_____